

“БҮТЭЭЛЧ ТЭМДЭГЛЭЛ” ШАЛГУУР, ТҮҮНИЙГ АШИГЛАСАН ҮР ДҮН

Л.Мөнхтуяа, дэд профессор, МУБИС

Abstract: In the era of technology, teachers are required to have comprehensive competences including academic, professional, curricular, communicative and research [1]. Due to the flow of information which has been increasing day by day, everybody including teachers and students should be able to search for the information they need, collect and process it accurately, disseminate it to others by working together. However, whether those skills are acquired at an appropriate level has become the issue of not only teachers and but also everybody. The skill of student-teacher of processing the information is based on working on the books and textbooks which are relevant to their profession.

In my ten-year experience, one of the factors which affect students' skill of working on the information is the skill of writing a creative note. Students majoring in teacher-profession study a variety of source materials including theoretical and methodological textbooks, education policy documents such as standard, curriculum, textbooks and teacher handouts and use them for their learning process. However, class diagnosis and the results of formative and summative assessments show that students' knowledge and skills of native and foreign languages and the use of technical words and expressions is comparatively different from each other. Therefore, we searched for the possibility of improving their learning style and skill of processing scientific information by offering “a creative note”.

This article looks at “creative note” which is one of the criteria of the methodological experiment on “Issue-search-creative works” which has been carried out by the course “Informatics didactics” and its implementation.

Түлхүүр үг: оюутан, асуудал, эрэл хайгуул, бүтээл, давтамж, үнэлгээ

Удиртгал

Яагаад мэргэжлийн ном, сурах бичигтэй ажиллах чадварыг хөгжүүлэх ёстой вэ?

Оюутнууд “Мэдээлэл зүйн дидактик” хичээлээс ухаарч ойлгосон асуудлын агуулга, үзэл санааг өөрсдөө бие даан бататган ойлгох, хэрэглэх, тухайн асуудлыг олон талаас нь харж, бүтээлчээр боловсруулах, жишээ баримтаар баяжуулах, тодорхой дүгнэлт хийж өөрийн гэсэн итгэл үнэмшлийг олж авахад мэргэжлийн ном, сурах бичгийн хэрэглээ ихээхэн чухал юм.

Багш оюутнуудад мэргэжлийн ном, сурах бичгийг сурах үйл ажиллагаандаа хэрхэн хэрэглэх талаар арга зүйн зөвлөмжийг боловсруулж, хэрэглэсэн.

Үүнд:

1. Мэргэжлийн ном, сурах бичигт тусгасан асуудал (агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ)-ыг хэрхэн яаж судалж ашиглах удирдамж, ажлын хуудастай сайн танилцаж, ойлгосон байх;
2. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд ямар материалыг ямар түвшинд яаж ашиглахыг сайн төлөвлөх;
3. Ашиглаж буй материал нь оюутнуудын

багшлахуйн онол болон арга зүйн чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн, тэдний бие даасан үйл ажиллагааг дээшлүүлэх боломжтой байх;

4. Мэргэжлийн сурах бичиг, гарын авлагад тусгагдсан агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ нь суралцагчдын хэрэгцээнд нийцсэн, амьдрал ахуйн жишээгээр баяжигдсан эсэх, тэдний хүмүүжил, төлөвшилд нөлөөлж чадаж байгаа эсэхийг тодорхой аргачлалаар судалж, эргэцүүлэл хийх;
5. Оюутнуудын гүйцэтгэх үйл ажиллагааг олон хувилбартай, асуудлыг олон талаас нь бүтээлч байдлаар судлах боломжийг өгсөн байх.

Арга зүй

“Мэдээлэл зүйн мэргэжлийн дидактик” хичээлийн хүрээнд оюутан багшийн мэргэжлийн ном, сурах бичигтэй ажиллах чадварыг дээшлүүлэх “асуудал-эрэл хайгуул-бүтээл” арга зүйг боловсруулж хэрэгжүүллээ.

Уг арга зүйн онцлог нь:

1. Оюутан багшийн гарааны үнэлгээнд боловсруулалт хийнэ (Мэргэжлийн ямар нэгэн материалаас тэмдэглэл хийх, “Бүтээлч тэмдэглэл” шалгуурын дагуу үнэлэх)
2. Багш зааж буй хичээлээ дараах арга зүйгээр зохион байгуулна (Лекцийн материалын мэдээлэлд “багцлах” аргаар боловсруулалт хийж, ЯАГААД? ЯАЖ? гэсэн сэдлийг оюутнуудад өгч асуудал дэвшүүлэх; Семинарын хичээлд оюутнууд багшийн өгсөн “ажлын хуудас”, түүний зааварчилгааны дагуу “тодорхой” сэдвийн хүрээнд эрэл хайгуул хийх, хамтран хэлэлцэх; Лабораторийн хичээлд өмнө хийсэн судалгааны үр дүнд “сэдэв”-ийн

дидактик боловсруулалт хийж, эргэцүүлэл бичих, багшаас онол, арга зүйн зөвлөгөө авах).

3. Туршилтын үр дүнг боловсруулж, дүн шинжилгээ хийнэ (багш “бүтээлч тэмдэглэл” шалгуурын хуудсанд оюутнуудын гүйцэтгэлийг тэмдэглэх; цуглуулсан өгөгдөлдөө боловсруулалт хийх, барианы үнэлгээ хийх; үр дүнг оюутнуудад танилцуулах, хэлэлцүүлэг хийх).


Үр дүн

Уг хичээлийг судалсан оюутнуудын хүрсэн үр дүн бодитой, хэмжигдэхүйц болгохын тулд “бүтээлч тэмдэглэл”-ийн аргачлал боловсруулан туршлаа. Багшийн боловсруулсан “бүтээлч тэмдэглэл”-ийн шалгуураар 55 оюутны гүйцэтгэлд үнэлгээ хийсэн үр дүнг авч үзье.

Хүснэгт 1
“Бүтээлч тэмдэглэл”-ийн гарааны үнэлгээ

Үзүүлэлт	Хангалттай	Боломжийн	Дунд зэрэг	Хангалтгүй
1. Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун эзэмшсэн байдал	1	7	14	33
2. Судалгааны аль нэг арга хэрэглэсэн байдал	2	6	12	35
3.Тухайн сурах бичгээс олж авсан шинэ санаа	9	11	17	18
4. Нэгтгэн дүгнэлт хийсэн байдал	0	5	14	36
5. Үг, хэллэг, найруулга	0	7	16	32
6. Эргэцүүлэл	5	14	15	21
7. Тайлбарлан ярих байдал	4	10	17	24

Зураг 1
Гарааны үнэлгээний сарнилын үзүүлэлт



Зураг 1-ээс хангалттай үнэлгээг үзүүлэлт 3-аар 9 оюутан, хангалтгүй үнэлгээг үзүүлэлт 2-оор 35 оюутан авсан байна. Эндээс оюутнууд судалж буй материалаас олж авсан агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээний талаарх шинэ санаагаа тэмдэглэх байдал бусад үзүүлэлтээс өндөр бол баримт бичиг, задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх аргыг эзэмшсэн байдал дутагдалтай байна.

Улирлын туршид оюутнуудын мэргэжлийн ном, сурах бичигтэй ажиллах чадварыг дээшлүүлэхийн тулд оюутны бүтээлч тэмдэглэл хийсэн давтамжийг дараах хүснэгтээр үзүүлье.

Хүснэгт 2
Оюутны бүтээлч тэмдэглэл хийсэн давтамж

Үзүүлэлт	Давтамж					Нийт
	5	4	3	2	1	
Тоо	7	12	12	13	11	55
Хувь	12	22	22	24	20	100,0


Судалж буй “асуудал”-ын хүрээнд оюутны бүтээлч тэмдэглэлийн гүйцэтгэлийн үр дүнг авч үзвэл 56% нь 3-5 удаа, 44% нь 1-2 удаагийн давтамжтай байна.

Дээрх үйл ажиллагааны үр дүнд оюутнуудын барианы үнэлгээ ямар байгааг авч үзье.

Хүснэгт 3
“Бүтээлч тэмдэглэл”-ийн барианы үнэлгээ

Үзүүлэлт	Хангалттай	Боломжийн	Дунд зэрэг	Хангалтгүй
1. Шинжлэх ухааны нэр томъёо, ухагдахуун эзэмшсэн байдал	6	12	17	20
2. Судалгааны аль нэг арга хэрэглэсэн байдал	10	12	16	17
3. Тухайн сурах бичгээс олж авсан шинэ санаа	12	15	18	10
4. Нэгтгэн дүгнэлт хийсэн байдал	4	13	15	23
5. Үг, хэллэг, найруулга	5	13	16	21
6. Эргэцүүлэл	9	15	19	12
7. Тайлбарлан ярих байдал	9	14	18	14

Зураг 2
Барианы үнэлгээний сарнилын үзүүлэлт



Зураг 2-оос хангалттай үнэлгээг үзүүлэлт 3-аар 12 оюутан, хангалтгүй үнэлгээг үзүүлэлт 4-өөр 23 оюутан авсан байна. Эндээс оюутнууд судалж буй материалаас олж авсан агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээний талаарх шинэ санаагаа тэмдэглэх байдал ахисан бол судалгааны аргаар хийсэн боловсруулалтаа нэгтгэн дүгнэх чадвар дутагдалтай байна.

“Мэдээлэл зүйн дидактик” хичээлээр хэрэгжүүлсэн “асуудал-эрэл хайгуул-бүтээл” арга зүйн “Бүтээлч тэмдэглэл” шалгуурын хэрэгжилтийн харьцуулалтыг дараах хүснэгтээр үзүүлээ.

Хүснэгт 4

“Бүтээлч тэмдэглэл” шалгуурын үр дүнгийн харьцуулалт

Үнэлгээ	Хангалттай (4)		Боломжийн (3)		Дунд зэрэг (2)		Хангалтгүй (1)	
	тоо	хувь	тоо	хувь	Тоо	хувь	тоо	хувь
Гараа	3	5	9	16	15	27	28	51
Бариа	8	15	13	24	17	31	17	31
Зөрүү	5	9	4	7	2	4	-11	-20

Хүснэгтээс үзвэл оюутнуудын хангалттай үнэлгээ 9 %, боломжийн үнэлгээ 7 %, дунд зэрэг үнэлгээ 4 %-иар өсч, хангалтгүй үнэлгээ 20 %-иар буурсан байна.

Хэлэлцүүлэг

“Мэдээлэл зүйн дидактик” хичээлийг заахдаа ажлын хуудас ашигласаар ирсэн бөгөөд энэ нь зөвхөн гүйцэтгэлийг илэрхийлж байв. Иймд уг хичээлийг судалсан оюутнуудын хүрсэн үр дүнг бодитой, хэмжигдэхүйц байдлаар үнэлэхийн тулд “бүтээлч тэмдэглэл” шалгуурыг боловсруулж

ашигласан бөгөөд оюутны мэргэжлийн ном, сурах бичигтэй ажиллах чадварт тодорхой ахиц гарч байгааг илрүүлэх боломжтой нь харагдлаа. Иймд багш бэлтгэх сургуулийн бусад судлагдахууны “мэргэжлийн дидактик” хичээлийн хүрээнд ашиглах боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Оюутнуудын мэргэжлийн ном, сурах бичиг, эрдэм шинжилгээ, арга зүйн цахим болон хэвлэмэл мэдээлэлтэй ажиллах чадварыг дээшлүүлэхийн тулд өөрийн боловсруулсан аргачлалыг туршсаны үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Туршсан арга зүйн үр дүнгээс харвал оюутнуудын мэргэжлийн нэр томьёо, ухагдахуун эзэмшилт, судалгааны арга хэрэглэсэн байдал, мэдээллийг нэгтгэн дүгнэх чадвар, үг хэллэг, найруулгын чадварыг дээшлүүлэх шаардлагатай байна. Үүний тулд багш мэргэжилтэн бэлтгэх сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан багш боловсролын багц, мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлийн залгамж холбоо, хамаарлын талаар хавсарга судалгаа хийж, хэрэгжүүлбэл зохино.

“Бүтээлч тэмдэглэл” шалгуур нь оюутны мэргэжлийн ном, сурах бичигтэй ажиллах чадварыг илрүүлэх нэгэн хэмжүүр болж чадах нь арга зүйн хэрэгжилт, туршилт, үр дүнгийн боловсруулалтаар харагдлаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Боловсролын Их Сургууль БШСТТ. (2009). “Багш мэргэжлийн стандартын харьцуулсан судалгаа -2011”. Улаанбаатар

Монгол Улсын Боловсролын Их Сургууль. (2014). Багш, математикийн боловсрол-ын сургалтын төлөвлөгөө. Улаанбаатар

Баасандорж, Ц. (2008). Сургалтын арга: эрэл, олз. Улаанбаатар

Бурмаа, Ц. (2012), “Суралцагчдад англи хэл сурах арга барил эзэмшүүлэх арга зүй”

Золзаяа, Б., Мөнхтуяа, Л., ба бус. (2011). Дижитал ном унших арга зүй. Улаанбаатар

Оюунцэцэг, Д, ба бус. (2004). Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зүй. Улаанбаатар

<http://www.macalester.edu/max/science/howtoread/>

<http://www.bowdoin.edu/~jburciag/study/textbooks.html>

http://go.hrw.com/resources/go_sc/hst/HSTSW081.PDF

“Бүтээлч тэмдэглэл” шалгуурын хүснэгт

Сургалтын материал (Сурах бичиг/гарын авлага)-ын нэр:

Судалсан бүлэг сэдэв:.....

Судлаач оюутны нэр:

Анги, бүлэг:

Үзүүлэлт	Шалгуур			
	Хангалттай	Боломжийн	Дунд зэрэг	Хангалтгүй
1. Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун эзэмшсэн байдал				
1.1 Ухагдахуун нэр томьёоны жагсаалт	4	3	2	1
1.2 Толь бичгийн тайлбар ашиглалт	4	3	2	1
2. Судалгааны аль нэг арга хэрэглэсэн байдал				
2.1 Баримт бичгийн судалгаа	4	3	2	1
2.2 Задлан шинжлэх арга	4	3	2	1
2.3 Нэгтгэн дүгнэх арга	4	3	2	1
3. Тухайн сурах бичгээс олж авсан шинэ санаа				
3.1 Агуулга	4	3	2	1
3.2 Арга зүй	4	3	2	1
3.3 Хэрэглэгдэхүүн	4	3	2	1
3.4 Үнэлгээ	4	3	2	1
4. Нэгтгэн дүгнэлт хийсэн байдал				
4.1 Судалгаанд суурилсан дүгнэлт	4	3	2	1
5. Үг, хэллэг, найруулга				
5.1 Зөв бичих дүрэм	4	3	2	1
5.2 Найруулга	4	3	2	1
6. Эргэцүүлэл				
6.1 Асуулт	4	3	2	1
6.2 Бүлэг сэдвийг судалсны эцэст эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага	4	3	2	1
6.3 Өөрийн сурах үйл ажиллагаандаа өгсөн үнэлэлт	4	3	2	1
6.4 Тулгарсан бэрхшээл	4	3	2	1
7. Тайлбарлан ярих байдал				
7.1 Мэргэжлийн үг хэллэг	4	3	2	1
7.2 Логик дэс дараалал	4	3	2	1
7.3 Илтгэх ур чадвар	4	3	2	1

Санал, зөвлөгөө:

.....

.....